



ДАРХАН-УУЛ АНАГААХ
УХААНЫ СУРГУУЛЬ

Анагаахын Ухааны Төслийн Их Сургууль

1942

АШУУИС-ИЙН ДАРХАН-УУЛ АЙМАГ
САЛБАР АНАГААХ УХААНЫ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 3/49

Дархан сум


Төгсөлтийн өмнөх сургалтад оюутан
элсүүлэх журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйл, 31 дүгээр зүйлийн 31.1.5 дахь хэсэг, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/170 дугаар тушаал “Босго оноо тогтоох тухай”, 2024 оны А/143 дугаар тушаал “Оюутан элсүүлэх журам”, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Ректорын үүрэг гүйцэтгэгчийн 2024 оны А/132 дугаар тушаал “Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх журам батлах тухай”, тус сургуулийн захиргааны зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

- “АШУУИС-ийн Дархан-Уул аймаг салбар Анагаах ухааны сургуулийн Төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, Төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх мэргэжлийн хөтөлбөр, элсэлтийн ерөнхий шалгалтын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Сургалтын албаны дарга (Б.Хандаа), элсэлтийн цахим үйл ажиллагааг хариуцан ажиллахыг Эрдэм шинжилгээ, мэдээлэл технологийн албаны Ахлах арга зүйч Ц.Давхай), элсэлтийн санхүүгийн бүртгэл, төлбөр тооцоотой холбоотой үйл ажиллагааг хариуцан ажиллахыг ахлах няглан бодогч (Н.Уранчимэг) нарт тус тус үүрэг болгосугай.
- Тушаал гарсантай холбогдуулан Захирлын 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/33 дугаар тушаалаар батлагдсан “АШУУИС-ийн Дархан-Уул аймаг салбар Анагаах ухааны сургуулийн Төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хяналт шинжилгээ, үнэлгээний албаны дарга (Ц.Нандинсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Б.БАЯСГАЛАНМӨНХ



Джигүүлжилт

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дархан-Уул аймаг салбар Анагаах ухааны сургуулийн 2024-2025 оны хичээлийн жилд Төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх журам

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн (цаашид АШҮҮИС гэх) Дархан-Уул аймаг салбар Анагаах ухааны сургуульд 2024-2025 оны хичээлийн жилд төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэхэд Монгол Улсын Дээд боловсролын тухай хууль, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоол “Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусlamж олгох, дэмжлэг үзүүлэх журам”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны A/143 дугаар тушаал “Оюутан элсүүлэх журам”, 2024 оны A/170 дугаар тушаал “Босго оноо тогтоох тухай”, 2023 оны 115 дугаар тогтоол “Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл батлах тухай”, АШҮҮИС-ийн Ректорын үүрэг гүйцэтгэгчийн 2024 оны A/132 дугаар тушаалаар батлагдсан “АШҮҮИС-ийн төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх журам” болон энэхүү журмыг тус тус баримтална.
- 1.2. Элсэлтийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй, тэгш, хүртээмжтэй зохион байгуулна.
- 1.3. Элсэлтийн журам, оюутан элсүүлэх хөтөлбөр, элсэлтийн ерөнхий шалгалт (ЭШ)-ын оноо тооцох болон элсэлттэй холбоотой бусад мэдээллийг сургуулийн <http://www.mnunms-da.edu.mn> цахим хуудсанд байршуулна.
- 1.4. 2024-2025 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх хяналтын тоог АШҮҮИС-ийн Удирдах зөвлөл тогтоож, АШҮҮИС-ийн Ректорын тушаалаар баталгаажуулна.
- 1.5. Засгийн газар хооронд болон АШҮҮИС, Дархан-Уул аймаг салбар Анагаах ухааны сургуультай байгуулсан хамтын ажиллагааны гэрээгээр суралцах гадаад иргэдийг АШҮҮИС-ийн Ректорын тушаалаар шууд элсүүлэн суралцуулж болно.
- 1.6. АШҮҮИС-ийн Удирдах зөвлөлөөс баталсан элсэлтийн хяналтын тоонд багтаан элсэлтийг жилд 2 удаа зохион байгуулж болно.

Хоёр. Элсэлтийн комисс

- 2.1. АШҮҮИС-ийн Дархан-Уул аймаг салбар Анагаах ухааны сургуулийн Захирлын тушаалаар батлагдсан элсэлтийн комисс нь элсэлтийн хугацаа товлох, зохион байгуулах, хяналт тавих, ур чадварын шалгалт, комиссын гишүүдийн ажил үүргийг хуваарилах, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, журмаар зохицуулаагүй асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 2.2. Элсэлтийн комиссын дарга нь сургуулийн захирал, гишүүдэд сургалтын албаны дарга, эрдэм шинжилгээ, мэдээлэл технологийн албаны дарга, арга зүйч, мэргэжилтэн, багш нар байна.

Гурав. Бүртгүүлэгчдэд тавигдах шаардлага

- 3.1. Сургуулийн <http://www.elselt.mnums-da.edu.mn> цахим бүртгэлийн системд бүртгүүлсэн байна.
- 3.2. Бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой иргэнийг дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт элсүүлнэ.
- 3.3. Элсэлтийн ерөнхий шалгалтын (ЭЕШ), Боловсролын үнэлгээ арга зүйн байгууллага (БУАЗБ)-ын цахим хүчин төгөлдөр батламжтай (2022, 2023), эсвэл гадаадын ерөнхий боловсролын шалгалтын оноог БУАЗБ-аар дүйцүүлсэн батламжтай байна.
- 3.4. Тухайн хөтөлбөрийн элсэлтийн шалгалтын хичээлзэр босго оноог хангасан байх;
- 3.5. АШҮҮИС-ийн бусад салбар сургуульд байхгүй хөтөлбөрөөр зарим бус нутгаас элсэгчдийг цахим хэлбэрээр элсүүлнэ.
- 3.6. БШУ-ны сайдын 2024 оны А/143 дугаар тушаалыг үндэслэн дараах тохиолдолд ЭЕШ-ын оноо шаардахгүйгээр элсүүлэн суралцуулна. Үүнд:
 - 3.6.1. Дээд боловсролын дипломтой иргэн (голч дүн 2.8 ба түүнээс дээш)
 - 3.6.2. Дэд бакалаврын дипломтой элсэгч мэргэжлийн дагуу бакалаврын хөтөлбөрт элсэх
 - 3.6.3. Бакалавр, техникийн боловсрол эзэмшсэн иргэн дэд бакалаврын хөтөлбөрт элсэх
 - 3.6.4. Элсэн суралцах мэргэжлийн чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан, 30-аас дээш насны иргэн
 - 3.6.5. Гадаад болон дотоодын ерөнхий боловсролын сургуульд суралцаж бүрэн дунд боловсрол эзэмшсэн Монгол улсын иргэн олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг шалгалтын дүн, оноог БУАЗБ-аар дүйцүүлэн тооцуулсан батламжтай байна.
 - 3.6.6. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн олон улсын болон улсын төрөлжсөн олимпиадын эхний байрт шалгарсан
 - 3.6.7. Спорт, урлагийн өндөр ур чадвартай 5 хүртэлх бүртгүүлэгчийг шалгаруулж элсүүлж болно. (Олимп, тив, дэлхийн медальт болон шагналт байранд шалгарсан, улсын өсвөр үеийн, улсын идэрчүүдийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байранд шалгарсан бүртгүүлэгчдийг амжилтаар нь эрэмбэлнэ)
- 3.7. Нэмэлт элсэлтийг хяналтын тоонд багтаан тодорхой мэргэжлийн хөтөлбөрөөр орон нутаг харгалзахгүйгээр элсүүлнэ.
- 3.8. АШҮҮИС-ийн Дархан-Уул аймаг салбар Анагаах Ухааны Сургууль хандив болон хууль бус төлбөр хураамжийг элсэлтийн үйл ажиллагааны үеэр авахгүй болно.

Дөрөв. Элсэх хүсэлт гаргах

- 4.1. АШҮҮИС-ийн Дархан-Уул аймаг салбар Анагаах ухааны сургуульд элсэх хүсэлтыг элсэлтийн цахим системд (<http://elselt.mnums-da.edu.mn>) гаргана. Элсэлтийн цахим систем 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр нээгдэж, элсэлтийн ерөнхий шалгалтын дүн нийтэд зарлагдсан сүүлийн өдрийн 18.00 цагт хүртэл бүртгэнэ.
- 4.2. Элсэгч нь элсэлтийн цахим системд (<http://elselt.mnums-da.edu.mn>) шаардлагатай хувийн мэдээллээ үнэн зөв, бүрэн гүйцэд оруулах бөгөөд

алдаатай мэдээлэл оруулснаас гарах сөрөг үр дагаврыг элсэгч өөрөө хариуцна.

Тав. Хөтөлбөр сонгох, элсэгчдийг шалгаруулах

- 5.1. Элсэгчийн элсэлтийн ерөнхий шалгалтын дүн нийтэд зарлагдаж, blockchain-д орсон байна.
- 5.2. Элсэлтийн elselt.mnms-da.edu.mn бүртгэл мэдээллийн цахим системд элсэгч БҮАЗБ-ийн кодоор бүртгүүлэн нэвтэрч, элсэх хөтөлбөрөө сонгон баталгаажуулах товч дарна.
- 5.3. Сувилахуй, эх барихуй, уламжлалт анагаахын засалч, хөдөлгөөн засалч, эм зүйч (шаталсан), сувилахуй (шаталсан) бакалаврын хөтөлбөрөөр, сувилахуй, эх барихуй, уламжлалт анагаах ухааны сувилахуй, эм найруулагч, лабораторийн техникч дэд бакалаврын хөтөлбөрөөр босго оноо хангасан элсэгчдийг шууд элсүүлнэ.
- 5.4. Анагаахын суурь боловсрол (хүний их эмч, монгол анагаах ухааны их эмч, шүдний их эмч, хүүхдийн эмч), эрүүл мэндийн суурь боловсрол (эм зүйч, био-анагаах судлаач) хөтөлбөрөөр элсэгчдийг элсэлтийн шалгалтын нэг, хоёрдугаар хичээлийн өндөр онооны нийлбэр дүнгийн дарааллаар жагсааж хөтөлбөр сонгуулна.
- 5.5. Элсэлтийн ерөнхий шалгалтын “Элсэлтийн шалгалт-1”-д заасан хичээлийн аль нэгийг “Элсэлтийн шалгалт-2”-т шилжүүлэн тооцож болно.
- 5.6. Элсэгч нь хөтөлбөр сонголтын хураамжаа 2024 оны 7-р сарын 8-ны өдрийн 18.00 цагаас өмнө цахимаар төлснөөр баталгаажих бөгөөд төлбөрийг буцаан олгохгүй.
- 5.7. Анагаахын суурь боловсрол, Эрүүл мэндийн суурь боловсролын хөтөлбөрөөр элсэгчид элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн тухайн хот, орон нутгийн хяналтын тоонд онооны жагсаалтаар өрсөлдөнө.
- 5.8. Элсэгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст онооны нийлбэр тэнцсэн тохиолдолд онооны хувь болон бүрэн дунд боловсролын үнэмлэхийн үнэлгээний дундаж хувийг харьцуулж шийдвэрлэнэ.
- 5.9. Анагаахын суурь боловсрол, Эрүүл мэндийн суурь боловсролын хөтөлбөрөөр хуваарь сонгосон элсэгч нь хуваариас татгалзсан, баталгаажуулалт хийгээгүй тохиолдолд хяналтын тоонд багтаан нэмэлт элсэлтийг 2024 оны 07-р сарын 08-наас 18-ны өдрүүдэд зохион байгуулж дуусгана.
- 5.10. Цахим элсэлтийн үед элсэлтийн бичиг баримт хуурамчаар бүрдүүлсэнтэй холбоотой үүсэх хариуцлагыг элсэгч өөрөө хүлээнэ.
- 5.11. Шаталсан хөтөлбөрөөр элсэгчдийн өмнөх түвшний боловсрол эзэмшсэнийг батлах баримт бичиг, дипломын лавлагaa (E-Mongolia, www.hemis.edu.mn) тодорхойлолтыг үндэслэн бүртгэлийг баталгаажуулна.
- 5.12. Элсэгч тогтоосон хугацаанд хөтөлбөр сонголт хийгээгүй тохиолдолд элсэхээс татгалзсанд тооцно.

Зургаа. Суралцах эрх олгох

- 6.1. Орон нутгийн хяналтын тоонд багтаж хөтөлбөр сонгосон элсэгч нь 48 цагийн дотор сургалтын төлбөрийн 50 хувиас доошгүй, анагаахын суурь боловсрол, эрүүл мэндийн суурь боловсролын хөтөлбөр сонгосон элсэгч сургалтын төлбөрийн 100 хувиас доошгүй төлж, “АШУҮИС-ийн Дархан-Уул

аймаг салбар Анагаах ухааны сургуульд оюутан суралцуулах гэрээ"-г
Оюутны албатай байгуулснаар суралцах эрх баталгаажна.

- 6.2. Суралцах эрх цүцлагдсан тохиолдолд сургалтын төлбөрийг оюутан
суралцуулах гэрээний дагуу шийдвэрлэнэ.

Долоо. Элсэгчдийг бүртгэх

- 7.1. Элсэгчдийн бүртгэл 2024 оны 8 дугаар сарын 3 дахь долоо хоногт
нээгдэнэ. Элсэгч нь дараах бичиг баримтыг бүрдүүлж цахимаар болон
биеэр ирж бүртгүүлнэ. Үүнд:
- 7.1.1. Бүрэн дунд боловсролын гэрчилгээ (хэрэв түүнээс дээш шатны
боловсрол эзэмшсэн бол диплом)
 - 7.1.2. Сурагчийн хувийн хэрэг
 - 7.1.3. Элсэлтийн ерөнхий шалгалтын батламж
 - 7.1.4. Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг
 - 7.1.5. Сүүлийн 6 сарын дотор авхуулсан 3.5x4.5 хэмжээтэй цээж зураг
 - 7.1.6. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан баримт
 - 7.1.7. Бүртгэлийн хураамж - 50.000 төгрөг
 - 7.1.8. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоо,
шинжилгээний хөнгөлөлттэй төлбөр - 50.000 төгрөг
 - 7.1.9. "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд элсэгчдийн төгөл -
25.000 төгрөг
 - 7.1.10. Бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн тохиолдолд бүртгэлээс хасах
бөгөөд хариуцлагыг элсэгч өөрөө хүлээнэ.
- 7.2. Бакалавр, дэд бакалаврын хөтөлбөрөөр элсэгчид нь Боловсролын
зээлийн сангийн Оюутны хөгжлийн зээл, буцалтгүй хөнгөлөлттэй зээлээр
суралцах бол холбогдох материалыг бүрдүүлнэ.
- 7.3. Элсэгч сургалтын төлбөрийг АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг салбар
Анагаах ухааны сургуулийн ХААН БАНК дахь 5046180073 тоот дансанд
тушаана.
- 7.4. Сургалтын төлбөр төлж, холбогдох бичиг баримтыг бүрдүүлсэн элсэгчдийг
АШУҮИС-ийн Захирлын тушаалаар баталгаажуулна.
- 7.5. Шинэ элсэгчдэд зориулсан удиртгал хичээлийг 2024 оны 8 дугаар сарын
сүүлийн 7 хоногт зохион байгуулна.
- 7.6. Шинээр элссэн оюутнууд нэгдсэн журмаар сургуулийн "Сайхан-Сэтгэл"
клиник эмнэлэгт эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд
хамрагдана.
- 7.7. Элсэлтийн хяналтын тоо гүйцээгүй хөтөлбөрөөр нэмэлт элсэлт зарлах
бөгөөд орон нутаг харгалзахгүй бүртгэнэ.

Найм. Гадаад элсэгчдэд тавигдах шаардлага

- 8.1. Төгсэлтийн өмнөх сургалтад суралцах гадаадын иргэн хүсэлтээ 2024 оны
07 дугаар сарын 01-ны дотор цахимаар гаргана.
- 8.2. Гадаад иргэн сургуулийн цахим хуудсанд байршуулсан өргөдлийн маягт,
эрүүл мэндийн хуудсыг бөглөж, дараах баримтын хамт илгээнэ.
- 8.2.1. Гадаад иргэний үнэмлэх (identification card), гадаад паспорт болон
түүнтэй адилтгах бичиг баримт (хүчинтэй хугацаа 3-аас дээш жил)
 - 8.2.2. Боловсролын диплом (гэрчилгээ), дүнгийн хавсралт (англи эсвэл
монгол хэл рүү орчуулсан орчуулгын хамт)

- 8.2.3. Англи хэлний мэдлэг, чадварыг илтгэх (TOEFL, IELTS, TOEIC зэрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх) баримт, монгол хэлээр суралцах бол монгол хэлний шалгалтын дүн
- 8.2.4. Цээж зураг (3.5x4.5 хэмжээтэй, сүүлийн 3 сарын дотор авхуулсан байх)
- 8.2.5. Эрүүл мэндийн хуудас (сэтгэцийн эмчийн дүгнэлт, HIV, HBV, HCV, TRNA, TB) шинжилгээнд сүүлийн 3 сар дотор хамрагдсан байх
- 8.3. Суралцах хүсэлт гаргасан гадаад иргэнд ажлын 10 хоногт багтаан хариуг холбогдох хаягаар хүргүүлнэ.
- 8.4. Суралцах эрх авсан гадаадын иргэн тухайн хичээлийн жил эхлэхээс 14 хоногийн өмнө дараах материалыг эх хувиар авчирч бүртгүүлнэ. Үүнд:
- Иргэний үнэмлэх (identification card), гадаад паспорт болон түүнтэй адилтгах бичиг баримт (хүчинтэй хугацаа 3-аас дээш жил)
 - Боловсролын диплом (гэрчилгээ), дүнгийн хавсралтыг англи эсвэл монгол хэл рүү орчуулсан орчуулгын хамт
 - Англи хэлний мэдлэг, чадварыг илтгэх (TOEFL, IELTS, TOEIC зэрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх) баримт, монгол хэлээр суралцах бол монгол хэлний шалгалтын дүн
 - Цээж зураг (3.5x4.5 хэмжээтэй, сүүлийн 3 сарын дотор авхуулсан байх)
 - Амь нас, эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд хамрагдсан баримт (Монгол улсын даатгалд заавал хамрагдсан байх)
 - Сургалтын хураамж төлсөн баримт (тухайн өдрийн Монгол банкны ханшаар байх)
 - Эрүүл мэндийн хуудас (сэтгэцийн эмчийн дүгнэлт, HIV, HBV, HCV, TRNA, TB) шинжилгээнд сүүлийн 3 сар дотор хамрагдсан байх

Ес. Ур чадварын шалгалтын зохион байгуулалт

- 9.1. Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлүүдэд ур чадварын шалгалтын оноог “Элсэлтийн шалгалт-1”-д зааснаас бусад хичээлд дүйцүүлэн тооцож болно. Ур чадварын шалгалтыг биологийн тестээр 3 хоногт багтаан үнэлнэ.
- 9.2. Ур чадварын шалгалтыг 100 хүртэл оноогоор үнэлж, хэмжээст оноонд харгалзуулан тооцох ба 60 болон түүнээс дээш оноогоор тэнцэнэ.
- 9.3. Ур чадварын шалгалтыг элсэлтийн комисс зохион байгуулна.
- 9.4. Ур чадварын шалгалтад тухайн хөтөлбөрт тавигдах хичээл I-ийн ЭЕШ-ийн босго оноо давсан оюутныг оролцуулна.
- 9.5. Мэргэжлийн онцлогоос хамааруулан дараах хэлбэр, агуулгыг өргөжүүлэн тусгай ур чадварыг үнэлж болно. Үүнд:

Индекс	Хөтөлбөр	Хэлбэр	Оноо
091704	Уламжлалт анагаахын засал	<ul style="list-style-type: none"> • Асуумж, • тест 	<ul style="list-style-type: none"> (50 оноо) • Ярилцлага (50 оноо)
091301	Сувилахуй	• Эсээ	Хүнлэг энэрэнгүй, ёс зүй,
091702	УАСувилахуй	• Ярилцлага	харилцааны эв дүй
091308	Эх барихуй		(бусдыг сонсох, ойлгох,
091602	Эм найруулагч		өөрийгөө илэрхийлэх,
091403	Лабораторийн техникч		бусдад туслах, эелдэг
			0-100
			0-100
			0-100
			0-100
			0-100

- 9.6. Сувилахуй, эх барихуй, хөдөлгөөн засал хөтөлбөрөөр элсэгчдээс ур чадварын шалгалтыг зохион байгуулж авна.
- 9.7. Ур чадварын шалгалтын хэмжээст оноог үндэслэн тухайн хөтөлбөрөөр элсэгчийг элсүүлнэ.
- 9.8. Ур чадварын шалгалтын үнэлгээ тооцох
- 9.8.1. Ур чадварын шалгалтыг 0-100 оноогоор аравны орны нарийвчлалтайгаар үнэлэх ба энэ нь анхдагч оноо болно.
- 9.8.2. Элсэгч тус бурийн ур чадварын шалгалтын анхны оноонд суурилсан гүйцэтгэлийн хувь буюу шалгалтын хэмжээст оноог мэргэжил тус бүрээр дараах байдлаар гаргана. Анхы оноо A, хэмжээст оноо X гэе. Энэ тохиолдолд шалгалтын хэмжээст оноо (X)-г хүснэгтэд заасны дагуу харгалзах томъёогоор тооцоолно. Үүнд:

№	Анхны оноо (A)	Хэмжээст оноо (X)	Бодох томъёо
1	0-59.9	200-479	
2	60-64.9	480-519	
3	65-69.9	520-559	X=480+(A-60)*8
4	70-74.9	560-599	
5	75-79.9	600-639	
6	80-84.9	640-679	
7	85-89.9	680-719	
8	90-94.9	720-759	
9	95-100	760-800	

- 9.9. Элсэгчийн ур чадварын шалгалтын оноо нь зөвхөн тус сургууль болон хөтөлбөрийн хувьд хүчинтэй.

АРАВ. БУСАД

- 10.1. Хичээл сонгон судлах хүсэлт гаргасан иргэнийг “Иргэнээр суралцагч” -аар бүртгэж болно.
- 10.1.1. Иргэнээр суралцагч нь бүрэн дунд боловсрол эзэмшсэн иргэн байх ба тухайн хичээлийн жилд 40 хүртэл багц цагийн хичээлийг судалж болно.
- 10.1.2. Иргэнээр суралцагч нь оюутны хөгжлийн зээл болон буцалтгүй тусламжид хамрагдах боломжгүй.
- 10.1.3. Иргэнээр суралцагч нь тус журмын гуравдугаар бүлэгт заасан шаардлагыг хангасан тохиолдолд үндсэн суралцагчаар бүртгэж суралцуулна.
- 10.2. АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг салбар Анагаах ухааны сургуульд оюутан элсүүлэх шаардлагыг хангасан хөгжлийн бэрхшээлтэй иргэн холбогдох хууль, тогтоол, журамд заасны дагуу сургалтын төлбөрийн санхүүгийн дэмжлэгт хамрагдах боломжтой.

Арван нэг. Элсэгчдэд үзүүлэх хөнгөлөлт, урамшуулал

- 11.1. Монгол улсын Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолоор тус сургуульд элсэн суралцагч нь дараах хөнгөлөлтүүдийг эдэлнэ. Үүнд:

- 9.6. Сувилахуй, эх барихуй, хөдөлгөөн засал хөтөлбөрөөр элсэгчдээс ур чадварын шалгалтыг зохион байгуулж авна.
- 9.7. Ур чадварын шалгалтын хэмжээст оноог үндэслэн тухайн хөтөлбөрөөр элсэгчийг элсүүлнэ.
- 9.8. Ур чадварын шалгалтын үнэлгээ тооцох
- 9.8.1. Ур чадварын шалгалтыг 0-100 оноогоор аравны орны нарийвчлалтайгаар үнэлэх ба энэ нь анхдагч оноо болно.
- 9.8.2. Элсэгч тус бурийн ур чадварын шалгалтын анхны оноонд суурилсан гүйцэтгэлийн хувь буюу шалгалтын хэмжээст оноог мэргэжил тус бүрээр дараах байдлаар гаргана. Анхы оноо A, хэмжээст оноо X гэе. Энэ тохиолдолд шалгалтын хэмжээст оноо (X)-г хүснэгтэд заасны дагуу харгалзах томъёогоор тооцоолно. Үүнд:

№	Анхны оноо (A)	Хэмжээст оноо (X)	Бодох томъёо
1	0-59.9	200-479	
2	60-64.9	480-519	
3	65-69.9	520-559	X=480+(A-60)*8
4	70-74.9	560-599	
5	75-79.9	600-639	
6	80-84.9	640-679	
7	85-89.9	680-719	
8	90-94.9	720-759	
9	95-100	760-800	

- 9.9. Элсэгчийн ур чадварын шалгалтын оноо нь зөвхөн тус сургууль болон хөтөлбөрийн хувьд хүчинтэй.

АРАВ. БУСАД

- 10.1. Хичээл сонгон судлах хүсэлт гаргасан иргэнийг “Иргэнээр суралцагч” -аар бүртгэж болно.
- 10.1.1. Иргэнээр суралцагч нь бүрэн дунд боловсрол эзэмшсэн иргэн байх ба тухайн хичээлийн жилд 40 хүртэл багц цагийн хичээлийг судалж болно.
- 10.1.2. Иргэнээр суралцагч нь оюутны хөгжлийн зээл болон буцалтгүй тусламжид хамрагдах боломжгүй.
- 10.1.3. Иргэнээр суралцагч нь тус журмын гуравдугаар бүлэгт заасан шаардлагыг хангасан тохиолдолд үндсэн суралцагчаар бүртгэж суралцуулна.
- 10.2. АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг салбар Анагаах ухааны сургуульд оюутан элсүүлэх шаардлагыг хангасан хөгжлийн бэрхшээлтэй иргэн холбогдох хууль, тогтоол, журамд заасны дагуу сургалтын төлбөрийн санхүүгийн дэмжлэгт хамрагдах боломжтой.

Арван нэг. Элсэгчдэд үзүүлэх хөнгөлөлт, урамшуулал

- 11.1. Монгол улсын Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолоор тус сургуульд элсэн суралцагч нь дараах хөнгөлөлтүүдийг эдэлнэ. Үүнд:

- 11.1.1. Бакалавр, дэд бакалаврын хөтөлбөрөөр суралцвал сургалтын төлбөрийн 50 хувийн хөнгөлөлт
- 11.1.2. Сувилахуй (бакалавр, дэд бакалавр), уламжлалт анагаахын сувилагч хөтөлбөрөөр элсэгч элсэлтийн ерөнхий шалгалтад 501-ээс дээш оноо авсан тохиолдолд 100 хувь, үргэлжлүүлэн суралцагч бол 2.8-3.0 хүртэл голч оноотой суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийн 70 хувь, 3.0 болон түүнээс дээш голч оноотой суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийг 100 хувь төр хариуцна.
- 11.1.3. Дээрх тэтгэлгийг хүсэгч нь сувилагч мэргэжлээр суралцаж төгсөөд орон нутагт 3-аас доошгүй жил, эсвэл нийслэлд 5-аас доошгүй жил мэргэжлээрээ тогтвортой ажиллах нөхцлийг хүлээн зөвшөөрсөн байна.
- 11.1.4. Дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрөөр зорилтод бүлгийн элсэгчид хүсэлт гаргавал буцалтгүй тусlamжид хамрагдана. Үүнд:
 - 11.1.4.1. Бүтэн өнчин
 - 11.1.4.2. Эцэг эх нь хоёулаа, эсхүл хагас өнчин бол эцэг/эх нь хөгжлийн бэрхшээлтэй өрх
 - 11.1.4.3. Хөдөлмөрийн чадвараа алдсан гишүүнтэй өрх
 - 11.1.4.4. Цаатан, Урианхай, Тува өрхийн нэг иргэн
 - 11.1.4.5. "Монголын сайхан бичигтэн" уралдааны эхний гурван байрт шалгарсан суралцагч
 - 11.1.4.6. Нэг гэр бүлийн 3 болон түүнээс дээш хүүхэд дотоодын сургалтын байгууллагад бакалаврын хөтөлбөрөөр зэрэг суралцаж байгаа тохиолдолд нэг суралцагч
- 11.2. Сургуулийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд Хөдөлгөөн засалч, Уламжлалт засалч хөтөлбөрөөр суралцагчдад сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлнэ.
- 11.3. Хөгжлийн бэрхшээлтэй шинээр элсэгч хүсэлт гаргасан тохиолдолд Захиргааны зөвлөлөөр хэлэлцэн, сургуулийн дотуур байрны төлбөрөөс нийгмийн хариуцлагын хүрээнд 100 хувь хүртэл чөлөөлж болно.
- 11.4. Сургуулийн гадаад хамтын ажиллагааны хүрээнд элсэгчдэд дараах боломжууд нээлттэй байна. Үүнд:
 - 11.4.1. Францын Мулан хотын Улаан загалмайн дэргэдэх Сувилахуйн Сургууль, Японы Жичи анагаах ухааны сургууль, Японы Мацуудо сургууль, Тайландын Чанг Май сургууль, ОХУ-ын Байгалийн Анагаах Ухааны Сургууль, БНХАУ-ын Хөх хотын Анагаах Ухааны Сургуулийн оюутнуудтай хамтарсан дадлага хийх, шалгуур хангасан тохиолдолд тухайн оронд дадлагын тайлан хамгаалах боломжтой.
 - 11.4.2. Сувилахуй, Сувилагч мэргэжлээр суралцах хугацаандаа герман хэлний B1 түвшин хангасан тохиолдолд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад үргэлжлүүлэн сурч, ажиллах боломжтой.
 - 11.4.3. Уламжлалт засалч хөтөлбөрөөр суралцагчид нь Япон улсад дадлага хийх боломжтой.

2024-2025 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх мэргэжлийн хөтөлбөр,
элсэлтийн ерөнхий шалгалтын жагсаалт

№	Хөтөлбөр	Элсэлтийн ерөнхий шалгалтын оноо тооцох хичээл					
		Хичээл 1	Босго оноо	Хичээл 2	Босго оноо		
1	Хүний их эмч*	Хими Математик	420 ба түүнээс дээш	Биологи Физик Математик	420 ба түүнээс дээш		
2	Шүдний их эмч*	Хими Биологи		Биологи Физик Математик			
3	Уламжлалт анагаахын их эмч*	Хими Биологи		Биологи Физик Математик			
4	Хүүхдийн их эмч*	Хими Математик		Биологи Математик Физик			
5	Био-Анагаах судлаач*	Хими Математик		Биологи Физик Математик			
6	Эм зүйч*	Хими Математик		Физик Математик			
7	Сувилахуй	Хими Математик	410	Математик Биологи Англи хэл Физик Монгол хэл Нийгэм судлал Үр чадвар	420		
8	Эх барихуй			Физик Математик			
9	Хөдөлгөөн засалч	Хими Математик	420	Математик Биологи Англи хэл Физик Монгол хэл Нийгэм судлал Үр чадвар	420		
10	Уламжлалт анагаахын засал			Физик Математик			
11	Сувилахуй (дэд бакалавр)	Хими Математик	410	Математик Биологи Англи хэл Физик Монгол хэл Нийгэм судлал Үр чадвар	420		
12	Эх барихуй (дэд бакалавр)			Математик Биологи Англи хэл Физик Монгол хэл Нийгэм судлал Үр чадвар			
13	Эм найруулагч	Хими Биологи	410	Математик Биологи Физик	410		
14	Уламжлалт анагаахын сувилагч			Математик Биологи Физик			
15	Лабораторийн техникч			Математик Биологи Физик			
16	Сувилахуй (1жил)	Бага эмч, Бага эмч-Сувилагч, Сувилагч мэргэжил эзэмшсэн байна.					
17	Эх барихуй (1жил)	Эх баригч, Эх баригч-Бага эмч, Эх баригч-Сувилагч мэргэжил эзэмшсэн байна.					
18	Эм зүйч (3+3жил)	Эм найруулагч мэргэжил эзэмшсэн байна.					

*Дээрх хөтөлбөрөөр элсэгчид нь Элсэлтийн ерөнхий шалгалтын нэг, хоёрдугаар хичээлийн өндөр онооны нийлбэр дүнгийн дарааллаар хөтөлбөр сонгоно.